




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3698 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.6%



НИЙТ ХАДГАЛАМЖ
16.9 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
31.1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
959 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
8%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,

Инфляци: 2020 онд: **6.6%**,

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**

Инфляци: 2020 онд: **5.6%**,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 10-р сарын байдлаар (3259) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 14.6 хувиар буурсан бол, зарлага 30 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 3259 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 580 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 0.57 төгрөгөөр буурав.

Аравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 175 төгрөг буюу 6.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.57 төгрөг буюу -0.02 хувиар буурч, өмнөх улирлаас 0.61 хувиар өсч 2853.60 төгрөг болов. 9-р сард гадаад валютын нөөц 3.69 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 1 хувиар өсч, оны эхнээс 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 2.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 10-р сарын байдлаар өмнөх сараас 0.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, оны эхнээс 2.3 хувь өсөв. Инфляцийн түвшин 2017 оны 10 дугаар сард 6.9 хувь, 2018 оны 10 дугаар сард 6.3 хувь, 2019 оны 10 дугаар сард 7.6 хувь гарч байсан бол 2020 оны 10 дугаар сард 2.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.2 пунктээр буурсан байна.




Гадаад худалдааны тэнцэл 1549 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны аравдугаар сард нийт барааны эргэлт 10423 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 8.3, импорт өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 1549 сая ам.долларын ашигтай гарав.



10-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.mongolbank.mn

Нийт хадгаламж 2020 оны 10-р сард 16.9 их наяд төгрөг болж өмнөх сараас 169.3 тэрбум төгрөг буюу 1 хувиар нэмэгдсэн бол өнгөрсөн оны мөн үеэс 22.7 хувиар буюу 3133.7 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 12074.6 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 3.7 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 4848.7 тэрбум төгрөг болж өмнөх сараас 5.1 хувиар буурав. Үүнээс төгрөгийн хадгаламж 71 хувь, валютын хадгаламж 29 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 13.7 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 53 хувийг эзэлж байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 10 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 139.1 (0.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 993.4 (5.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.9 (51.9%) их наяд төгрөг нь иргэдийнх байна. Монголбанкнаас хэрэглээний зээлийг хязгаарлаж, макро бодлогын арга хэмжээ авснаар оны эхэнд хэрэглээний зээл 17 орчим хувиар буурчээ. Тодруулбал, банкуудын олгох зээл эхний хагас жилд 4.6 хувь буурч, 17.3 их наяд төгрөг болжээ. Энд автомашин, цахилгаан бараа авах зэрэг иргэдийн хэрэглээний зээл 17 хувь буурсан нь голлон нөлөөлжээ.

САРЫН ОНЦЛОХ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ 2,59 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЭВ

- Энэ оны гуравдугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,598 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 118.1 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өсжээ. Тайлант үед нийт 34.9 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийж хөрвөх чадвар 1.3 хувь болж буурсан байна. ТОП-20 индекс өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 1,925.9 нэгжээр буюу 9.9 хувиар буурч 17,531.6 нэгж болсон байв. Хөрөнгийн бирж "Үнэт цаасны үнийн индекс тооцох журам"-ыг шинэчлэн баталж, 2018 оны хоёрдугаар сараас эхлэн үнэт цаасны бүртгэлийн нэг, хоёрдугаар ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан индексүүдийг тооцжээ.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

- Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн журам өөрчлөгдөж, энэ оны 10 дугаар сарын 1-нээс жилийн зээлийн хүүг 6 хувь байхаар тогтоосон. Шинэчлэгдсэн журмыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойш 10 дугаар сарын 22-ны байдлаар нийт 15.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 221 иргэнд олгоод байна. Тус санхүүжилтийн 9.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүхий 157 хүсэлтийг Монголбанкнаас, 5.9 тэрбум төгрөгийн 64 хүсэлтийг арилжааны банкуудаас гаргасан байна. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн журам өөрчлөгдсөнөөр энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө авсан орон сууцны зээлийн хүүг 8 хувь, харин энэ оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн зээлийн хүүг 6 хувь байхаар тогтов.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 10-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 10-р сар 2020 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn